

ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Даалгавар №	Агуулга /даалгавар/	Зөв хариулт Хувилбар "А"	Зөв хариулт Хувилбар "Б"	Оноо	Онооны тайлбар
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР					
1.	Нийгмийн давхраажилт	C	C	1	
2	Нийгмийн хэв маягууд	C	A	1	
3	Нийгмийн байр суурь	D	C	1	
4	Нийгэм дэх шилжих хөдөлгөөн	D	B	1	
5	Нийгмийн өөрчлөлт	B	D	1	
6	Олон улсын харилцааны улс бус оролцогч	E	C	1	
7	Монгол улс ба Олон улсын харилцааны улс бус оролцогчдын хамтын ажиллагаа	A	E	1	
8	Монгол улсын "Гуравдагч хөршийн бодлого	C	A	1	
9	Зөөлөн хүчний бодлого	D	D	1	
10	Соёлын үйлдвэрлэл	D	D	1	
11	Соёлын даяршил	A	E	1	
12	Соёлын адилсал	E	B	1	
13	Соёлын эрх чөлөө	D	E	1	
14	Соёлын цочирдол	A	C	1	
15	Ардчилалын үнэт зүйлс ба Монгол улсын үндсэн хууль	C	B	1	
16	Иргэний нийгэм түүний мөн чанар, үндсэн шинж	E	C	1	
17	Сонгууль, сонгуулийн тогтолцоо	A	B	1	
18	Орчин үеийн нийгэм улс төрийн үйл явцад хэвлэл мэдээлэлийн хэрэгслийн үзүүлэх нөлөөлөл	I	B	1	
19	Улс төрийн институт	C	C	1	
20	Макро эдийн засаг	C	D	1	
21	Төр эдийн засгийг ямар бодлогоор зохицуулдаг вэ?	A	B	1	
22	Төрийн мөнгө зээлийн бодлогын зорилго юу вэ?	C	A	1	
23	Гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого	B	D	1	
24	Гадаад хөрөнгө оруулалт	E	E	1	
25	Хөдөлмөрийн эрх зүй	C	E	1	
26	Хүний эрх ба үндсэн хууль	D	C	1	
27	Өмчийн эрхийг хуулиар хамгаалах нь	D	D	1	
28	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь	A	B	1	
29	Захиргаа, иргэдийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх нь	A	A	1	
30	Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм	E	A	1	
31	Нийгмийн хамгаалал	C	D	1	

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР							
№		Хувилбар “А”		Хувилбар “Б”			
32.1А	Нийгэм нийгмийн харилцаа	Соёл нь нийгмийн амьдралд тодорхойлогч үүрэг гүйцэтгэж, түүний бүхэллэг шинж ба хөгжлийг нөхцөлдүүлж амьдралын бүхий л хүрээ, түүний дотроос эдийн засгийн хүрээнд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг.		Газрыг эрчимтэй ашиглаж, тариалангийн талбайн үржил шим муудаж, халуун орны ой сөнөж, устах аюул нүүрлэж байна. Томоохон хотуудад агаарын бохирдлын асуудал	1	Хариулт бүрэн бол 2 оноо, Дутуу бол 1 оноо, буруу бол 0 оноо	
32.В		Хүн хүнтэй харьцах амьд харилцааны нөлөөг бууруулдаг.		Газрыг эрчимтэй ашигласнаар үржил шим нь муудсан, ой мод устсан, хүн ам хэт өссөн, хотжилт агаар бохирдсон зэрэг нь байгаль орчин доройтоход хүргэсэн.	2	Хариулт бүрэн бол 2 оноо, Дутуу бол 1 оноо, буруу бол 0 оноо	
32.С		Төлөв	Жишээ Холбооны компаниуд хэрэглэгчидээ татахын тулд шинэ бүтээгдэхүүн гаргана. Хямд үнэ санал болгоно ингэснээр хүний хөдөлмөрт илүү давуу тал бий болно.		<ul style="list-style-type: none"> - Нар салхины эрчим хүчийг ашиглах, - Байгалийн хийг ашиглах 	2	А. Хувилбар: Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох В. Хувилбар: Бүрэн 2 оноо, Дутуу бол 1 оноо, буруу бол 0 оноо
		Чадна	Хэрэглэгчидийн цагийг хэмнэнэ.				
	Чадахгүй	Эдийн засгийн хөшүүргэ ашиглахгүй бол өрсөлдөх чадамж үгүй болно.					
32.Д		<p>А. Хүссэн мэдээлэлээ авна .</p> <p>Б. Банк эрүүл мэндийн салбараас үйлчилгээ авна .</p> <p>В. Соёлын солилцооны өргөн боломж авна.</p> <p>Г. Мэдлэг боловсролоо дээшлүүлнэ.</p> <p>Д. Мэдээлэлээ хүссэн газраас авах боломжтой .</p>		<p>1. Нийгмийн хөгжил</p> <p>2. Байгал орчны нөлөө цөлжилт,</p> <p>3. Хотжилт бөөгнөрөл</p> <p>4. Байгалын баялаг зүй зохисгүй ашиглалт</p> <p>5. Цахим орчны нөлөө</p>	5	Бүрэн хариулт бичилттэй бол 5 оноо, Хариулт тус бүр зөв бол тус бүр 1 оноо, дөхүүлсэн бол 0.5 оноо	
33.А	Улс төр	Ашиг сонирхолоо илэрхийлэх		Ардчилсан бус дэглэмтэй	1	Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох	
33.В		Тодорхой зохион байгуулалт байхгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт ,бослого, үймээнийг хэлдэг		Сонгох эрх, Сонгогдох эрх	2	Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох	
33.С		Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг		Харгислал хүний эрх эрх чөлөө алдагдана , цэрэг армийн хүчээр бүхнийг шийдвэрлэнэ.	2	Бүрэн хариулт бичилттэй бол 2 оноо, дутуу бол 1 оноо	
33.Д		<ul style="list-style-type: none"> - Ашиг сонирхлоо нэгтгэж байна. - Ашиг сонирхлоо илэрхийлж байна. - Ашиг сонирхлоо мэдээлэх 		<ul style="list-style-type: none"> • Авторитари дэглэм - Засаглалын эрх нэг хүний гарт бүрэн төвлөрсөн хувь хүний өмчийн хэлбэр бүрэн хязгаарлагдсан. • Тоталитари дэглэм- Тайлбар засаглалын эрх нэг намын тогтолцоонд тулгуурладаг, Хувь хүний зарим эрх эрх чөлөө нь хязгаарлагдмал, эдийн засгийн эрх бага хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн. • Ардчилсан дэглэм - Хүний эрх эрх чөлөөг хангасан нийгэм 	5	Хариулт тус бүрд 5 оноонд багтааж задалж тооцох, хариулт тус бүр 1.66.6 оноо, огт хариулт бичээгүй бол 0 оноо	

34.A	Эдийн засаг	Дотоод хөрөнгө оруулалт	Хөдөлмөрийн хөлс нь цалин орлогын төрөл болно	1	Бүрэн хариулт бичилттэй бол 1 оноо, дутуу бол 0.5 оноо
34.B		<ul style="list-style-type: none"> - Зээлийн хүүгийн орлого - Аж ахуйн нэгжийн ашиг 	<ul style="list-style-type: none"> - Өрхийн хэрэглээний зардал - Аж ахуйн хэрэглээний зардал 	2	Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох
34.C		<ul style="list-style-type: none"> - Төрийн зардал - Гадаад хэрэглээний зардал 	<ul style="list-style-type: none"> - Цалингийн орлого - Түрээсийн орлого 	2	Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох
34.D		<ul style="list-style-type: none"> - Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн ДНБ-7,6 , - Хөрөнгө оруулалтын хэмжээ I-1040 , - Импортын хэмжээ M-400, - Цэвэр хөрөнгө оруулалт Iг-620 	<ul style="list-style-type: none"> - Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн ДНБ=8.08 - Хөрөнгө оруулалтын хэмжээ I=3240 - Импортын хэмжээ M=320 - Цэвэр хөрөнгө оруулалт Iг 3240-540=2720 	5	<ul style="list-style-type: none"> - Бодолт 1- ийг хийсэн бол 2 оноо, дутуу бол 1 оноо - Бодолт 2-ыг бүрэн хийсэн бол 3 оноо, дутуу хийсэн бол 1.5 оноо
35.A	Эрх зүй	<ul style="list-style-type: none"> A.Амьд явах B. Эрүүл аюулгүй орчинд амьдрах C.Зорчин явах 	<ul style="list-style-type: none"> A. Эрүүл аюулгүй орчинд амьдрах B. Амьд явах эрхтэй..... 	1	Хариулт тус бүрд 1 оноонд багтааж задалж тооцох
35.B		<ul style="list-style-type: none"> A. Хүний амь нас хохирсон . B. Эрүүл мэндээрээ хохирсон 	<ul style="list-style-type: none"> A.Эрүүл мэндийн үйлчилгээ B.Төрийн үйлчилгээ алдагдал,нэгдсэн цахим үйлчилгээний алдаа 	2	Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох
35.C		Хууль захиргааны хэм хэмжээ зөрчсөн энэ хуульд шийтгэл оногдуулахад заасан үйлдэл ,эс үйлдэл ,эс үйлдэхүйг зөрчил гэнэ.	<ul style="list-style-type: none"> A.Гомдол B..өргөдөл C.Хүсэлт 	2	<ul style="list-style-type: none"> A. Хувилбарт бүрэн бол 2 оноо, дутуу агуулга 1 оноо B хувилбарт Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох
35.D		<ul style="list-style-type: none"> A.Торгох шийтгэх B. Тусгайлсан эрх хасах C. .Баривчлан шийтгэх 	Өөрт болон бусад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримтыг хүсэлт гэнэ.	5	<ul style="list-style-type: none"> A Вариантын хариулт бүрэн бол 5 оноо, Үүнээс: 1 хариулт зөв бол 1.66 оноогоор тус тус тооцно. B Вариант: Тодорхойлолт бүрэн бичсэн бол 5 оноо, Дөхүүлж хариулсан бол 2.5 оноо

ХУВИЛБАР “А”

Хугацаа 80 минут

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР:

1. Социализмын үеийн давхраажилтийг малчдын, ажилчдын, сэхээтний, номенклатура гэсэн ангийн бүтэцтэйгээр тодорхойлсон эрдэмтэнг олно уу.

А.Судлаач Ц.Уртнасан В.Судлаач Б.Энхцэцэг С.Судлаач Х.Гүндсамбуу D.Судлаач О.Мөнхбат

2. Социологчид орчин үеийн нийгэмд эдийн засгийн баялаг, орлогын хэмжээ, ажил мэргэжлээр ялгагдах ямар ангиас нийгэм тогтдог гэж тайлбарладаг вэ?

А. Дээд, дунд, доод В. Брахман, кшатрий, войшья, шудра С. Ажилчин, малчин, сэхээтэн
D. Уламжлалт гэрийн боол Е. Боолчлол, язгуур, каст, анги

3. Хүмүүс баялаг, алдар хүнд, нөлөөлөл, хүндэтгэл, эрх мэдэл зэрэг үнэ цэнтэй бүхнийг олж авах адил бус боломжоороо ялгаатай, тэгш бус нөхцөлд амьдарч байгаа нь юунаас шалтгаалж байна вэ?

А. Төрийн хамаарал В. Иргэншил С. Соёл D. Байр суурь Е. Газар зүйн байршил

4. Байр суурьт нөлөөлөх хувийн хүчин зүйлст хамаарах өгөгдлийг сонгоно уу.

А. Авьяас чадвар В. Хичээл зүтгэл С. Шаргуу хөдөлмөр D. Дээрх бүгд

5. Г. Ленски Ж.Ленски нар нийгмийн хэв маягийг дараах байдлаар илрүүлсэн. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу..

Ан агнуурын нийгэм	Цэцэрлэг аж ахуйн нийгэм	Аж үйлдвэрийн нийгэм
--------------------	--------------------------	-------	----------------------

А. Мал аж ахуйн нийгэм В. Газар тариалангийн нийгэм С. Аж үйлдвэржсэний дараах нийгэм

6. нь хувийн, сайн дурын үндсэн дээр бий болсон, үүрэг даалгаварт чиглэсэн олон нийтийн байгууллага юм. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.

А. Улс оролцогч В.Улс бус оролцогч С. Ундэстэн дамнасан корпораци

D.Олон улсын байгууллага Е. Олон улсын төрийн бус байгууллага

7. 1997 онд Шанхайн Хамтын Ажиллагааны байгууллагын хүрээнд ямар улсын удирдагчид уулзаж дэлхий «Олон туйлт» байх ёстой гэж тунхагласан бэ?.

А. ОХУ, БНХАУ. В. БНХАУ, Казакстан. С. Киргизстан, ОХУ D. Тажикистан, Узбекстан.

8. Зөв харгалзуулна уу.

А	Зөөлөн хүчний бодлого.	Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зараг бүх арга хэрэглээ тэнцвэртэй хоршуулах чадвар.
В	Хатуу хүчний бодлого	Албадлага, урамшууллаар бус харин бусад улсын Сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дунд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар.
С	Ухаалаг хүчний бодлого	Их гурнууд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ.
А. А1 В2 С3		В. А3 В2 С1
		С. А2 В3 С1

9. Монгол улс хэдэн оноос "Гуравдач хөрш"-ийн шинэ бодлогыг баримтлах,болсон бэ?

А. 1924 он. В.1961он. С.1998он. D.1990он. Е.2005он

10. Олон улсын туршлагаас харахад соёлын үйлдвэрлэлийг "Утаагүй үйлдвэрлэл" гэж тайлбарласан утгыг олно уу.

А. Хүний биед сөрөг нөлөөгүй В. Эдийн засгийн алдагдалгүй

С. Хүний хөдөлмөрийг хөнгөвчилсэн. D. Байгаль орчинд хор хөнөөлгүй

11.Соёлын даяаршлын тодорхойлолтыг сонгоно уу.

А. Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг хэлнэ.

В. Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл, үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт, нийлүүлэлтийн тоголцоог хангасан үйлдвэрлэлийн салбарыг хэлнэ.

С. Түүх, соёл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйл, үнэлэмж, уламжлал зэрэг соёл хоорондын харилцааны олон хэлбэрийг багтаасан өөр соёлын орчинтой биечлэн танилцах аяллыг хэлнэ.

12. Манай улсын судлаачид “Соёлын ижилсэл”, “Соёлын өөрийншил”, “Соёлын өвөр төрх” гэх мэтээр ямар ойлголтыг нэрлэж байгаа вэ? А. Соёлын үйлдвэрлэл В. Соёлын аялал жуулчлал ... С. Соёлын даяаршил D. Соёлын орон зай E. Соёлын адилсал
13. Соёлын эрх чөлөөний суурь зарчим гэж юу вэ? А. Соёлын ялгаатай байдлыг ойлгох В. Хүлцэн тэвчиж, хүндэтгэн хүний ёсоор хамтран амьдрах, харилцан ойлголцохыг эрмэлзэх С. Соёлыг нэгтгэх D. А ба В E. А ба С
14. “Б”-ийн эцэг эх нь хотод томилогдож ажиллах үед, шинэ сургуульд сурч, найз нөхөдтэй болжээ. Эхний 3 сар түүний хувьд маш хүндрэлтэй санагдлаа. Энэ тохиолдолд? А. Соёлын цочирдолд оров В. Орон нутгийн шилжих хөдөлгөөн С. Өсвөр насны сэтгэл зүйн онцлог .. С. Түр зуурын хямрал D. Бүх насны хүмүүст тулгардаг асуудал
- 15.1990 оны дараах төрийн бодлогоос аль нь илүүц вэ?. А. Хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, түүнийхээ үр шимээр амьдрах В. Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг амьдрал, үйл ажиллагаандаа бодитой хэрэгжүүлэх С. Үг хэлэх, хэвлэн нийтлэх, эдлэлдэн нэгдэх, эрх чөлөөнд хэм хэмжээ тогтоох D. Улс төрийн харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэх
- 16.Иргэний нийгмийн гол шинжид үл хамаарахыг олно уу ? А. Хүний эрх, эрх чөлөөг хуулийн хүрээнд адил тэгш эдлүүлдэг В. Эрх зүйт төрийг төлөвшүүлэх С.Эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх D.Иргэдийн оролцооны хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх E. Нийгмийн нөөцөөс хүртэх арга замыг олоход хүмүүст дэмжлэг үзүүлэх
- 17.Улс төрийн сонгууль явуулахдаа дотроо энгийн олонх,үнэмлэхүй олонх, харьцангуй олонх гэсэн аргатай тогтолцоо аль вэ? А. Мажоритори тогтолцоо В. Пропорциональ тогтолцоо С.Холимог Тогтолцоо
- 18.Хэвлэл мэдээллийн сувгийн мэдээллийн зорилго нь ямар байх ёстой вэ? А.Үнэн бодитой В.Тогтмол С.Шуурхай D.Хүртээмжтэй E.Багтаамжтай сайтай F.Идэвхтэй G. Ашигтай H. Чиглэсэн I. Дээрх бүгд
- 19.Зөв харгалзуулна уу?

A	Тогтолцооны дэд систем	1	Төр болон Улс төрийн институтд мэдээлэл дамжуулах сувгийн үүрэг гүйцэтгэх
B	Мэдээлэл харилцааны дэд систем	2	Сонирхолыг илэрхийлэх- Сонирхолыг нэгтгэх-Сонирхолыг хэрэгжүүлэх
C	Хэм хэмжээ- Зохицуулалтын дэд систем	3	Улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объекын чиг үүргийг тодорхойлох
A. A1 B2 C3		B.A3 B2 C1	
		C. A2 B1 C3	

20. ДНБ-ийг орлогоор тооцох үзүүлэлтэд хамаарагдахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү. А. Цалингийн орлого В. Түрээсийн орлого С. Шууд татварын орлого D. Аж ахуйн нэгжийн ашиг
- 21.Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого бол.....юм. Цэгийн оронд зөв өгөгдлийг нөхөж бичнэ үү. А. Сангийн буюу төсвийн бодлого В. Мөнгө, зээлийн бодлого С. Олон улсын худалдаа D. Гадаад худалдааны бодлого

22. $a.M = \frac{PQ}{T}$ үед эдийн засагт ямар нөхцөл үүсэх вэ? М-Гүйлгээнд байх мөнгөний хэмжээ PQ- Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт үнийн дүн T-Мөнгөний эргэлтийн хурд

- А. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж мөнгө үнэ цэнээ алдаж улмаар инфляци үүснэ.
 В. Эдийн засагт мөнгөний хомсдол үүсэж нийт эрэлт буурна.
 С. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ, үйлдвэрлэсэн бараа үйлчилгээний үнийн дүнтэй тэнцэж тогтворжино.
 D. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээнд өөрчлөлт гарахгүй.

23.Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлэх вэ?

- A. Улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа
 B. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа
 C. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа
 D. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа

24.Портфелийн хөрөнгө оруулалт,Шууд хөрөнгө оруулаоттай харьцуулахад ямар давуу талтай вэ?

- A.Хөрвөх чадвар өндөр B.Урт хугацаатай C. Илүү найдвартай . D.Алдагдалгүй E.Дээрх бүгд .

25. Хөдөлмөрийн гэрээг байгуулах нөхцөлөөр нь хэрхэн хуваадаг вэ?

- A. Ажил олгогч ба ажилтан B.Гол ба туслах C.Хугацаатай ба хугацаагүй
 D.Улирлын болон түр E.Хүнд ба хэвийн

26.Эх сурвалжийг уншаад асуултанд хариулна уу.Эрх зүйд захирагдах ёсны тодорхойлолтод хамаарахгүйг олно уу.

Эх сурвалж:Захиргааны байгууллагын аливаа шийдвэр хууль ёсны эсхээс үл хамаарч чиглэгдсэн этгээддээ тодорхой үр дагавар үүсгэж байдаг тул үүнд “Хуульд үндэслэн бодит шаардлагад нийцсэн байх”шаардлагыг тавьдаг.Энэхүү шаардлага нь төрийн гүйцэтгэх эрх мэдэл хуулиар нөлөөтэй хязгаарлагдсан байх тухай “Эрх зүйд захирагдах ёсны зарчим”-аас улбаатай бөгөөд Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд дур зоргын дэг журам үйлчилж байна уу?Эрх зүйд тулгуурласан дэг журам үйлчилж байна уу гэсэн утгаар уг зарчмын агуулга тодохойлогдсон.

- A.Хууль дүрэм журам хүн бүрд тэгш үйлчилж байна. B.Үндсэн хуулийн дагуу цогцлоон бий болгосон
 C.Шудрага үр нөлөө бүхий хүний эрхийг дээдэлсэн эрх зүйд захирагдах ёс бүрэлдэн тогтсон.
 D. Шүүхийн байгууллага нь чадварлаг, хараат байна. E. Ардчилсан үндсэн хууль бүхий эрх зүйт төрийг иргэд нь оролцож бий болгоно.

27. Оюуны үнэт зүйл болон түүнийг эзэмшсэнээр ашиг орлого олох эрхтэй байх нь хөрөнгийн ямар хэлбэрт хамаарах ойлголт вэ?

- A. Эдийн эрх B.Эдийн хөрөнгө C.Үл хөдлөх хөрөнгө D. Эдийн бус хөрөнгө

28. Хууль зүйн зөвлөгөө өгөх төвд дараахь асуулт ирсэн байна. “Би одоо 16 настай. 11 дүгээр ангид суралцдаг. Ангийн найзуудтайгаа хамтран шивэх, хэвлэх зэрэг компьютер, бичиг хэргийн үйлчилгээ үзүүлдэг компани байгуулах гэсэн юм.”Таны бодлоор тухайн хүүхэд компани байгуулан үйл ажиллагаа эрхлэх боломжтой юу?

- A. Боломжгүй. Учир нь тухайн хүүхэд насанд хүрээгүй учраас эрх зүйн үр дагавар бүхий харилцаанд бие даан оролцохгүй.
 B. Боломжтой. Учир нь тухайн хүүхэд 16 насанд хүрсэн учраас бие даан байгуулж болно.
 C. Боломжтой. Эцэг эх нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эрхэлж болно.
 D. Боломжгүй. Яагаад гэвэл тухайн үйл ажиллагааг эрхлэх санхүү мөнгөний асуудлаа шийдэж чадахгүй.

29. Захиргааны хэргийн шүүхийн гол зорилгод аль нь үл нийцэх вэ?

- A. Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас зөрчигдсэн эрхийг хамгаалах
 B. Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэхийг хянах
 C. Эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох D. Иргэн байгууллагад учирсан хохирлыг барагдуулах

30. Дараах өгөгдлийг зөв холбоно уу ?

1	Протокол	A	Хэргийг шийдвэрлэх,гэм буруу хохиролыг эцэслэн тогтоох						
2	Шүүх	B	Хуульчлан дагаж,мөрдөх албагүй,зөвлөмж, уриалгын шинжтэй баримт бичиг						
3	Арбитр	C	Хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүхийн бус арга						
4	Конвенц,Пакт	D	Хүчин төгөлдөр үйлчилж буя гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг						
5	Тунхаглал	E	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ						
A. 1B2A3E4C5D		B.1B2A3E4D5C		C.1B2A3D4E5C		D.1C2A3B4E5D		E.1D2A3C4E5B	

31. Өндөр насны тэтгэврийн хэмжээ, үүсэх үндэслэл, нэмэгдлийг зөв харгалзуулна уу.

A	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх үндэслэл	1	Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж хөдөлмөрийн хөлсний 45 хувиар						
B	Тэтгэврийн хэмжээ	2	20-иос дээш шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувийн нэмэгдэл олгоно						
C	Тэтгэврийн нэмэгдэл олгох үндэслэл	3	Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй.						
A. A1 B2 C3		B. A2 B3 C1		C. A3 B1 C2		D. A1 B3 C2		E. A3 B2 C1	

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР.

32. 1831 онд анхны цахилгаан шуудан илгээж байсан бол 1876 онд анхны телефон утсыг хэрэглэсэн ба харин 1973 оноос утасгүй үүрэн телефон нэвтэрч эхэлсэн. Манай улсад 1998 оноос үүрэн холбооны анхны үйлчилгээ эхэлж байсан бол эдүгээ Мобиком, Юнивижн, Скайтел, ЖиМобайл гэсэн 4 оператор үйл ажиллагаа явуулж байна. Гар утас хүмүүсийн амьдралд гүнзгий нэвтэрч бага насны цэцэрлэгийн хүүхдүүдээс бусад бүх насныханы хэрэглээ болсон байна.

A. Бүтэц чиг үүргийн онолд нийгмийн өөрчлөлтийн хүчин зүйлүүдийг дурдахдаа соёлыг ямар ойлголттой хамт дурддаг вэ?

.....
.....

B. Гар утасны хэрэглээ нь хүмүүсийн харилцаан дахь ямар төрлийн хүчин зүйлийн нөлөөг бууруулж байна гэж үздэг вэ?.....

C. Үүрэн холбооны дээрх 4 компанийн хэрэглэгчийнхээ хүрээг тэлэх гэсэн өрсөлдөөний үр дүн нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж чадах уу? Хэрхэн дүгнэн үзэж байгаагаа жишээний хамт бичнэ үү.

Төлөв	Жишээ
Чадна	
Чадахгүй	

D. ГАР утас харилцаа холбооны хэрэгсэл болохоос гадна өөр ямар ямар үүрэгтэй байж болохыг бичнэ үү. Зөв бичсэн жишээ бүр 1 оноо болно.

- A. b. c.
d. e.

33. Төв аймгийн Заамар сумын иргэд төрөлх нутаг орныхоо унаган төрх алдагдаж, байгаль орчинтой зүй бусаар харьцаж байгааг эсэргүүцэн жагсжээ. Энэ тохиолдолд сонирхлын бүлгийн үүргийн аль үүрэгт багтах вэ? ?

A.

B. Тодорхойгүй шинжтэй сонирхолын бүлэг гэж юуг хэлэх вэ?

.....

C. Эвсэл холбооны шинжтэй сонирхолын бүлэг гэж юу вэ?

.....

D. Сонирхлын бүлгүүдийн үндсэн үүрэг юу вэ? нэрлэ .

A. B.

C.

34. А. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлох аргыг зардлаар тооцох гэнэ. Аж ахуй нэгжүүдийн хөрөнгө оруулалтын зардлыг юу гэж нэрлэдэг вэ?

A.

B. ДНБ-ийг тооцох орлогын төрлүүдээс хоёрыг нэрлэнэ үү?

.....

C. ДНБ-ийг тооцох зарлагын төрлүүдээс хоёрыг нэрлэнэ үү?

.....

2023-2024.

D.Монгол улсын 2015 оны ДНБ 23.134.067.9 сая төгрөг, нийт хүн амын тоо 3.026.870 бол нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцоолоорой.

ДНБ= 8000 С=5000 G=1800 NX=160 бол

/ДНБ=С+I+G+NX / хөрөнгө оруулалтын хэмжээг олоорой

/NX=X-M / Экспорт 560 байхад импортын хэмжээг олоорой

/I=Iг+D/ Элэгдэл 420 бол цэвэр хөрөнгө оруулалтыг олоорой

35. 2019 оны 1-р сарын 8-ны өглөө 06 цагийн орчимд Замын-Үүд сумын нутагт зам тээврийн осол гарчээ.9988 улсын дугаартай 45 хүний суудалтай автобус үл хөдлөх зүйл мөргөж осолджээ. Уг ослын улмаас 2 хүн нас барж 43 хүн гэмтэж бэртжээ.

A. Тохиолдолд хүний ямар эрхүүд зөрчигдөж байна вэ?

A. B. C.

B.Тохиолдолд тулгамдсан асуудал юу вэ? A. B.

C.Дээд албан тушаалтан нь тодорхой арга хэмжээ, тусламж үзүүлэхгүй байгаа тул иргэд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж зөрчигдсөн эрхээ хамгаалуулах болов. Захиргааны зөрчил буюу шийтгэл гэж юу вэ?

.....

D.Зөрчлийн тухай хуульд зааснаар зөрчил гаргасан этгээдэд ямар шийтгэл оногдуудаг вэ?

A. B. C.

.

ДҮГНЭХ ХЭСЭГ:

ХУВИЛБАР “А”

Нийт авсан оноо:	Гүйцэтгэлийн хувь:	Үр дүнгийн үнэлгээний түвшин	Шалгасан багшийн нэр, гарын үсэг

Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

ХУВИЛБАР “Б”

Хугацаа 80 минут

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР:

1. Энэхүү аргачлал нь цөөн хүн амтай орон нутагт ашиглаж болох томоохон хот сууринд ашиглахад хүндрэлтэй юм. Дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзнээс дээд ангид оруулж болно хэмээн судалсан эрдэмтэн хэн бэ?

А. Т.Парсонс В. Дэвис ба Мур С. Л.Уорнер D. К. Маркс, М.Вебер Е. Э.Дюркгейм

2. Дайн байлдаан, өр төлөөс эсвэл тоталитар дэглэмийн нөлөөгөөр давхраажилтын ямар хэв маяг үүссэн бэ?

А. Боолчлол В. Язгуур С. Каст D. Анги

3. Менежер, мэргэжилтний ажлын байранд ажиллагсдын дундаж цалин улсын дунджаас 100 мянган төгрөгөөр илүү байна. Үүнд тохирох онолын дүгнэлтийг олно уу.

А. Цагаан захтаны ажлын хөлс өндөр
В. Цагаан захтан, Хөх захтанаас дээгүүр цалин авдаг нь нийгэмд тогтсон ойлголт
С. Байр суурь нь цалин хөлс, орлогын хэмжээнд нөлөөлж байна
D. Байр суурь нь гэр бүлийн гарал үүслээс хамааралтай

4. “Ямар байр суурьт хүрэх вэ?” гэдэгт нөлөөлөх хүчин зүйл аль нь вэ?

А. Нийгмийн болон хувийн В. Хувийн болон Институтийн С. Бүлгийн болон Хувийн
D. Нийгмийн болон Хувийн Е. Дээрх бүгд буруу

5. Өнөө цагийн социологичдоос нийгмийг дараах хэв маягт хуваасан эрдэмтэнг сонгоно уу.

1. уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх нийгэм	2. Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм	3. Орчин үеийн дараах буюу аж үйлдвэржилтийн дараах нийгэм
А. Г.Ленски В. Ж. Ленски	С. Ф. Тённис D.Т. Билтон нарын	Е. А ба В

6. "Coca cola" компани нь улс бус оролцогчдын аль ангилалд хамаарах вэ?

А. Олон улсын байгууллага В. Олон улсын төрийн бус байгууллага
С. Үндэстэн дамнасан корпораци Е. Шашны байгууллага

7. 34. Монгол улс хэдэн онд АСЕАН-ны Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдсэн бэ?

А. 1924 он В. 1961 он С. 1998 он D. 1990 он Е. 2005 он

8. Зөв харгалзуулна уу.

A	Ухаалаг хүчний Бодлого	1	Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зараг бүх арга хэрэглээ тэнцвэртэй хоршуулах чадвар.
B	Зөөлөн хүчний бодлого.	2	Албадлага, урамшууллаар бус харин бусад улсын Сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дунд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар.
C	Хатуу хүчний бодлого	3	Их гурнууд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ.
A. A1 B2 C3		B. A3 B2 C1	
		C. A2 B3 C1	

9. Монгол улс 1990 оноос чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих үед хамгийн түрүүнд харилцаж эхэлсэн тэргүүлэх гуравдагч хөрш орон аль вэ?

А. Япон. В. БНСУ. С. Турк. D. АНУ.

10. Монгол улсын «Соёлын үйлдвэрлэл» үндэсний хөтөлбөрийн зорилгыг олно уу.

А. Соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх В. Соёлын салбарт хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх С. Улс, үндэстнийхээ арвин баялаг өв уламжлал, ёс заншил, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлөөг сэргээх. D. А ба В хариулт зөв Е. А, В, С хариулт зөв

11. Соёлын даяаршил нь олон талын боломжийг олгодог. Үүнд илүүц зүйлийг сонгоно уу.

А. Хүний эрхийн зөрчилтэй тэмцэх хамтын ажиллагаа сайжрах боломж
В. Соёл, боловсрол хариуцсан олон нийтийн байгууллагын үүрэг өсөн нэмэгдэх
С. Олон ургальч соёл дэлгэрч, янз бүрийн соёлыг мэдрэх боломж
D. Ямар ч төрлийн мэдээллийг хоромхон зуурт авах, өгөх боломж
Е. Мэдээлэл, бараа бүтээгдэхүүн, хүн хүчээ дэлхий даяар солилцох, хамтран ажиллах боломж хомс

12. Соёлын адилслын тухай ойлголт хэдэн оноос нийгэм, хүмүүнлэгийн ухаанд хэрэглэгдэж эхэлсэн бэ? A.1960 оны I хагас B.1970 оны II хагас C. 1980 оны I хагас

D. 1980 оны II хагас E. 1990 оноос

13.Соёлын эрх чөлөөний асуудалд хамаарахгүй өгөгдлийг сонгоно уу.

A. Соёлын, угсаатны, арьсны, бэлгийн чиг баримжааны, шашны, оюун санааны ялгаатай байдлыг үнэлэх. B. Нийгмийн бүлгүүдийн харилцан адилгүй санаа бодлыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах. C. Хувийн онцлогоос хамааран нээлттэй байж чадахгүй байгаа хүмүүст
..... манлайлах боломжийг олгох, дэмжих.

D. Амьдралын хэв маягийг тулгахгүй байх. E. Бусдыг хүлээн зөвшөөрөхгүй байх.

14.Өөр соёлын орчин нөхцөл тухайн хүний хүссэнээс огт өөр байх, бүтэлгүйтэх, сэтгэл ханамж мэдрэгдэхгүй байх үед үүсэх бухимдал, гутрал, түгшүүр гэх мэт сөрөг мэдрэмж үүсэх үеийн сэтгэл зүйн байдлыг хэрхэн нэрлэдэг вэ?

A.Сөрөг соёл B.Соёлын дасан зохицох үйл явц C.Соёлын цочирдол D. Соёлын шок

15. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоорой.

..... гэдэг нь ард түмэн олгосон эрх мэдлийн хүрээнд ажиллах хүрээнд төрийн хэлбэр, дээд эрх мэдлийг ард түмэнтэй хамтран эдлэх эрхийн тогтолцоо юм.

A. Улс төр C. Төр B. Ардчилал D. Улс төрийн үйл ажиллагаа

16.Мэдээллийн эрх чөлөөт орон зайг бий болгох нь иргэний нийгмийг төлөвшүүлэхэд төрийн бодлогын аль хүрээнд хамаарах вэ?

A.Эдийн засгийн хүрээ B.Нийгмийн хүрээ C.Оюун санааны хүрээ D.Улс төрийн хүрээ

17.Улс төрийн сонгууль явуулахдаа нийт саналын 2/3 эсвэл ¼ хувийн саналыг авсан тохиолдолд ялсанд тооцох аргыг хэрхэн нэрлэх вэ?

A.Энгийн олонх B.Үнэмлэхүй олонх C. Харьцангуй олонх

18.Хэвлэл мэдээлийн хэрэгсэлийн байгууллагын зорилго юу вэ?

A. Нийт иргэд чиглэсэн үнэн бодитой мэдээллээр шуурхай , тогтмол хангах
B. Хэвлэлийн бүхий л хэлбэрийг ашиглан үнэн бодитой мэдээллийг цаг алдахгүй хүргэх
C. Нийтлэг ,нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай тогтмол хангах

19. Зөв харгалзуулна уу.

a	Сонирхолын бүлэг, Иргэний хөдөлгөөн,Төрийн бус байгууллага	1	Сонирхолыг нэгтгэх
b	Улс төрийн нам, Эсвэл	2	Сонирхолыг илэрхийлэх
c	Төр,	3	Сонирхолыг хэрэгжүүлэх
A.A1 B2 C3		B.A3 B2 C1	
		C. A2 B1 C3	

20. ДНБ-ийг зардлаар тооцох үзүүлэлтэд хамаарагдахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү.

A. Өрх гэрийн хэрэглээний зардал B. Аж ахуйн нэгжийн зардал
C.Төрийн зардал D.Татварын зардал

21. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого бол.....юм. Цэгийн оронд зөв өгөгдлийг нөхөж бичнэ үү.

A. Сангийн буюу төсвийн бодлого B. Мөнгө, зээлийн бодлого
C. Олон улсын худалдаа D. Гадаад худалдааны бараа эргэлт

22. $b. M > \frac{PQ}{T}$ үед эдийн засагт ямар нөхцөл үүсэх вэ? M-Гүйлгээнд байх мөнгөний хэмжээ PQ-Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт үнийн T-Мөнгөний эргэлтийн хурд

A. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж мөнгө үнэ цэнээ алдаж улмаар инфляци үүснэ
B. Эдийн засагт мөнгөний хомсдол үүсэж нийт эрэлт буурна
C. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ, үйлдвэрлэсэн бараа үйлчилгээний үнийн дүнтэй тэнцэж тогтворжино.
D. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээнд өөрчлөлт гарахгүй

23.Валютын интервенци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.

A. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
B. Төв банкнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа
C. Төв банкнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа
D. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа

24.Портфелийн хөрөнгө оруулалт ямар онцлогтой вэ ?

- А.Гадаад компанийг хянах В.Үнэт цаасны хашийн өсөлтөөс орлого олох
С.Капитал импортолж байгаа орондоо маш ашигтай D.А ба В E.В ба С

25.Контракт гэрээг ямар тохиолдолд байгуулах вэ?

- А.Ажилтны нийгмийн нөхцөл байдлыг хангах
В.Ажилтныг хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нөхцөлд байгуулах
С.Ажил эрхлэлтийн жилээс хамаарч
D.Ажилтны насны онцлогоос шалтгаалж
E.Ажилтны онцгой авьяас чадварыг ашиглах нөхцөлд байгуулах

26.Эх сурвалж дээр ямар асуудлыг хөндсөн бэ?

Эх сурвалж:ХҮНИЙ ЭРХИЙН түгээмэл тунхаглал
1-р зүйл хүн бүр төрхөөсөө эрх чөлөөтэй нэр төр эрхийнхээ хувьд адил тэгш байна.
5-р зүйл Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах шийтгэх ёсгүй.

- А.Олон улсын эрх В.Хүний эрхийн түгээмэл С.Хүний эрхэм чанар D.Соёлын эрх чөлөө

27. Сурагч Бат Нийгмийн ухааны номоо өөрийн ангийн найз Дорждоо 2500 төгрөгөөр худалдан борлуулсан байна. Бат өмчлөгчийн ямар эрхээ хэрэгжүүлсэн бэ?

- А. Шилжүүлэх эрх В. Эзэмших эрх С. Ашиглах эрх D. Захиран зарцуулах эрх

28.Монгол улсын хуулиар бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хориглодог үйл ажиллагаануудыг нэрлэхдээ илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ?

- А. Казино мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх
В. Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн сурталчлах, худалдаалах
С. Пирамид буюу олон шатлалт арга замаар хууран мэхэлж, ашиг олох
D. Хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, худалдаалах

29. Тамхины хяналтын тухай хуулинд зааснаар кино театр, үзвэрийн газрууд, агаарын тээвэр, цэцэрлэг, бүх шатны сургууль, дотуур байрны гадна, дотор орчин, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн орон сууцны орц, цахилгаан шатанд тамхи татахыг бүрэн хориглосон байдаг. Тэгвэл иргэн болон байгууллага нь энэхүү хуулийн заалтыг зөрчвөл ямар хариуцлага хүлээлгэх вэ?

- А. Торгох В. Тусгайлан олгосон эрхийг нь цуцлах С. Баривчлах D. Хууль бус орлогыг хураах

30. Дараах өгөгдлийг зөв холбоно уу ?

1	Тунхаглал	A	Хэргийг шийдвэрлэх,гэм буруу хохиролыг эцэслэн тогтоох
2	Шүүх	B	Хуульчлан дагаж,мөрдөх албагүй,зөвлөмж, уриалгын шинжтэй баримт бичиг
3	Конивенц,Пакт	C	Хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүхийн бус арга
4	Арбитр	D	Хүчин төгөлдөр үйлчилж буя гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг
5	Протокол	E	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ

A. 1B2A3E4C5D B.1B2A3E4D5C C.1B2A3D4E5C D.1C2A3B4E5D E.1A2C3D4B5E

31. Өндөр насны тэтгэврийн хэмжээ, үүсэх үндэслэл, нэмэгдлийг зөв харгалзуулна уу.

A	Тэтгэврийн нэмэгдэл олгох үндэслэл	1	20-иос дээш шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувийн нэмэгдэл олгоно
B	Тэтгэврийн хэмжээ	2	Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй
C	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх үндэслэл	3	Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж хөдөлмөрийн хөлсний 45 хувиар

A. A1 B2 C3 B. A2 B3 C1 C. A3 B1 C2 D. A1 B3 C2 E. A3 B2 C1

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

32. 1. Газрыг эрчимтэй ашиглаж, тариалангийн талбайн үржил шим муудаж, халуун орны ой сөнөж, устах аюул нүүрлэж байна. Байгаль орчны доройтол цаашид ч гэсэн үргэлжилсээр байх төлөвтэй байна

2. Хөгжиж байгаа орнуудын хувьд хүн амын хэт өсөлт, эдийн засгийн хөгжил, хотжилт түргэссэнтэй холбоотойгоор байгаль орчныг хамгаалах, экологийн доройтолтой тэмцэх олон асуудал тулгарна.

3. Томоохон хотуудад агаарын бохирдлын асуудал ихээхэн бэрхшээл үүсгэнэ.

Агаарын бохирдлыг бууруулах үүднээс технологийн дэвшлийг ашиглан эрчим хүч бага хэрэглэдэг машин үйлдвэрлэх, нар, салхины эрчим хүчийг ашиглах, байгалийн хийг ашиглах чиглэлээр ихэд анхаарах болно.

4. Боловсролын хэрэгцээ улам бүр нэмэгдэх ба эдийн засаг технологийн дэвшил нь илүү сайн боловсролтой, мэргэжилтэй ажиллах хүчийг шаардах болно.

А. Дээрх эхийг сайтар уншаад байгаль орчны доройтолд хамаарах эшлэлийг олж бичнэ үү !

В. Байгаль орчныг хамгаалах, экологийн доройтолтой тэмцэх асуудал юунаас үүдсэнийг эхээс олж бичнэ үү !

С. Эхийг уншаад хотын агаарын бохирдлыг бууруулах талаар ямар ямар арга замууд байгааг бичнэ үү !

Д. Дэлхийн хэмжээнд гарж болох дээрх өөрчлөлтүүдээс манай оронд тулгарч байгаа асуудлуудаас 5-аас доошгүй жишээ нэрлэнэ үү !

33. Нэгэн улсад хувьсгал гарч, армийн генерал Ерөнхийлөгч болжээ. Ерөнхийлөгч хууль гаргаж, шүүгчдийг болон бусад төрийн албаны хүмүүсийг томиллоо. Таван жил тутамд ерөнхийлөгчийн сонгууль болно. Гэвч хэн ч ерөнхийлөгчтэй өрсөлдөхгүй.

А. Дээрх жишээнд дурдагдаж буй улс нь төрийн ямар дэглэмтэй вэ?

В. Сонгуулийн эрхийг нэрлэнэ үү?

С. Төрийн эрх мэдэл нэг хүний гарт төвлөрсөнөөр гарах сөрөг үр дагавар юу вэ?

Д. Улс төрийн дэлэмэийн ангилалыг нэрлэж тайлбарлах .

А..... В..... С.....

34. Дараах тодорхойлолтыг уншаад асуултуудад хариулна уу. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлох аргыг зардлаар тооцох гэнэ.

А. ДНБ-ийг орлогоор тооцоход хөдөлмөрийн хөлс нь.....орлогын төрөл юм.

В. ДНБ-ийг тооцох зардлын төрлүүдээс хоёрыг нэрлэнэ үү?

С. ДНБ-ийг тооцох орлогын төрлүүдээс хоёрыг нэрлэнэ үү?

Д. Монгол улсын 2017 оны ДНБ 25.154.087.2 сая төгрөг, нийт хүн амын тоо 3.112.320 бол нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцоолоорой.

ДНБ= 9000 С=4000 G=1500 X=260 бол

/ДНБ=С+I+G+NX / хөрөнгө оруулалтын хэмжээг олоорой

/NX=X-M / Экспорт 580 байхад импортын хэмжээг олоорой

/I=Iг+D/ Элэгдэл 520 бол цэвэр хөрөнгө оруулалтыг олоорой

Бодолт хийх :

35. 25 жил эрүүл мэндийн даатгал төлсөн малчин Д анх удаагаа хот газар бараадан эмнэлэгт үзүүлэхээр ирсэн. Гэхдээ түүнд санасны зоргоор эмчид үзүүлэх цаг, очер дараалал олдсонгүй. Яарч сандарч байгаад орон нутгаасаа авчирдаг 13А маягтаа орхиод ирсэн түүнд 20 гаруй жил эрүүл мэндийн даатгал төлсний хэрэг гарсангүй. Төлбөрөө төлөөд тусламж үйчилгээ авч болно гэсэн хариулттай нийслэлд хэд хоножээ. Өнөө цахим лавлах, үйлчилээ нь ч тус болсонгүй.

Тохиолдолд хүний ямар эрхүүд зөрчигдөж байна вэ?

A.

B.

В.Тохиолдолд тулгамдсан асуудал юу вэ?

A.

B.

С.Иргэд, захиргааны байгууллагатай харилцах ямар хэлбэрүүдийг ашиглаж илэрхийлдэг вэ?

A.

B.

C.

D.Орон нутгийн иргэн захиргааны байгууллагад хандсан хүсэлтэд юуг илэрхийлэх вэ? Өөрөөр хэлбэл хүсэлт гэж юу вэ?

.....
.....

ДУГНЭХ ХЭСЭГ:

ХУВИЛБАР “Б”

Нийт авсан оноо:	Гүйцэтгэлийн хувь:	Үр дүнгийн үнэлгээний түвшин	Шалгасан багшийн нэр, гарын үсэг